

**БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН  
АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2019 ОНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2019 оны 12 дугаар сарын 11-ний өдөр

Багануур дүүрэг

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	БИЕЛЭЛТ	Үнэлгээ
<b>НЭГ. ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ХАМТ ОЛНЫГ БҮРДҮҮЛЭХ</b>			
1	Албан хаагчдыг 7 хоногт 1 удаа спорт заалаар хангах	<ul style="list-style-type: none"> <li>Байгууллагын албан хаагч нарыг түрээслүүлэгч компани “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-ийн гэрээт зааланд долоо хоног бүрийн 5 дахь өдөр дасгал хөдөлгөөн хийлгэж байна.</li> </ul>	100%
2	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	<ul style="list-style-type: none"> <li>Бүх албан хаагч нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.</li> </ul>	100%
3	Албан хаагчдын бие бялдрын сорил, чийрэгжилтийн түвшинг үнэлж өмнөх жилийн мөн үетэй харьцуулан танилцуулах	<ul style="list-style-type: none"> <li>Нийт албан хаагчдаас бие бялдрын сорил авч чийрэгжилтийн түвшинг үнэлсэн. Хөдөлгөөний дутагдалтай албан хаагч байхгүй бөгөөд А болон В үнэлгээ авсан.</li> </ul>	100%
4	Нэмэлт ажил	<ul style="list-style-type: none"> <li>Өдөр бүр 11:00 цагт ажлын байрны дасгал хөдөлгөөн тогтмол хийж хэвшсэн.</li> <li>Эрүүл чийрэг хамт олныг бүрдүүлэх зорилгоор дүүргийн Эрүүл мэндийн төвөөс зохион байгуулсан аянд оролцож эрүүл ажлын байр төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.</li> </ul>	100%
<b>ХОЁР. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИНГ НЭМЭГДҮҮЛЭХ</b>			
5	Албан хаагч нарт ажиллах тав тухтай орчныг бүрдүүлж өгөх	<ul style="list-style-type: none"> <li>Байгууллагын оффисын өрөө нь техникийн зориулалттай өндөр тааз, цонхтой байсан тул албан хаагчдыг стандартын ажлын байраар хангах үүднээс засвар хийж, өрөөний цонхонд зориулалтын хөшгийг тогтоосон.</li> <li>Түрээслүүлэгч байгууллага болох Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-д хүсэлт тавьж ариун цэврийн өрөөний</li> </ul>	100%

		суултуур болон угаалтуурын холигчийг иж бүрэн солиулсан. Мөн холигчид ус цэвэршүүлэгч байршуулсан.	
6	Албан хаагчдад хоол унааны мөнгө олгох	<ul style="list-style-type: none"> <li>Албан хаагч нарт сар бүр хоолны 4500, унааны 500 төгрөг олгож байна.</li> </ul>	100%
7	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг дүгнэж хамт олны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, урамшуулах <ul style="list-style-type: none"> <li>Сар – ур чадварын нэмэгдэл олгох</li> <li>Хагас, бүтэн жил - үр дүнгийн нэмэгдэл олгох</li> </ul>	<p>Байгууллагын албан хаагч нарын ажлын биелэлтийг үнэлж, дотоод журмын дагуу ур чадварын болон үр дүнгийн урамшуулал олгосон. Үүнд.</p> <ul style="list-style-type: none"> <li>Албан хаагч нарын сарын ажлын гүйцэтгэлийг үнэлэн ур чадварын нэмэгдлийг олгосон.</li> <li>Албан хаагч нарын улирлын ажлын гүйцэтгэлийг үнэлж үр дүнгийн урамшууллыг олгосон.</li> </ul>	100%
8	Албан хаагч нарын ажлын гүйцэтгэл, үр дүн, ажилласан хугацаанд үндэслэн төрийн одон медаль, салбарын болон дүүргийн шагналуудад тодорхойлж өгөх	<ul style="list-style-type: none"> <li>Нийслэлийн 380 жилийн ойн медалиар Паркийн дарга болон Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн нар шагнуулав.</li> <li>Орчин цагийн архивын салбар үүсч хөгжсөний 92 жилийн ойг тохиолдуулан дүүргийн Засаг даргын Жуух бичгээр Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн шагнагдав.</li> <li>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн Жуух бичгээр шагнуулахаар парк байгуулагдсан цагаас ажилласан 3 албан хаагчийн материалуудыг 196 дугаар албан бичгээр нийслэлийн ЗДТГ-ын ТЗУХ-д 2019.11.20-нд хүргүүлсэн. Одоогоор хариу ирээгүй байна.</li> </ul>	100%
9	Байгууллагын 2019 оны шилдэг ажилтанг ажлын гүйцэтгэл болон хамт олны саналаар шалгаруулж, урамшуулах	<ul style="list-style-type: none"> <li>Байгууллагын 2019 оны шилдэг ажилтнаар Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер Б.Мөнгөнхуяг хамт олны саналаар шалгарсан тул мэргэжлийн программын сургалтад хамрагдах эрхээр шагнаж урамшуулав.</li> </ul>	100%
<b>ГУРАВ. АЛБАН ХААГЧДАД ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ</b>			
10	Албан хаагч шинэ орон сууцтай болох, хурим хийх тохиолдолд байгууллагын зүгээс мөнгөн дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Тайлант онд шинэ орон сууц авсан болон хурим хийсэн албан хаагч байхгүй байна.</li> </ul>	0%

11	Шинэ хүүхэдтэй болох, хүүхэд үрчилж авах тохиолдолд байгууллагын зүгээс мөнгөн дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Одоогийн байдлаар шинэ хүүхэдтэй болсон, хүүхэд үрчилж авсан албан хаагч байхгүй байна.</li> </ul>	0%
12	Олон улсын хүүхдийн баяр болон Шинэ жилийн үйл ажиллагааг зохион байгуулж албан хаагчдын хүүхдүүдийг хүлээн авч, холбогдох зардлын 50%-ийг байгууллага хариуцах	<ul style="list-style-type: none"> <li>Олон улсын хүүхдийн баяр буюу Монгол улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг 2019.05.31-нд зохион байгуулж албан хаагчдын хүүхдүүдийг хүлээн авч тэмдэглэн өнгөрүүлсэн.</li> <li>Шинэ жилийн баярын үйл ажиллагааг 2019.12.14-ний өдөр тэмдэглэн өнгөрүүлж, оны шилдэг ажилтнаа шалгаруулан, албан хаагч бүрийг баярын бялуугаар шагнав.</li> </ul>	100%
13	Албан хаагч 3 сараас дээш хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 43.3.4. дэх заалтыг үндэслэн албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлж, ажлын байрыг хэвээр хадгалж, мөнгөн тусламж үзүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Тайлант онд биеийн байдал муудсан албан хаагч байхгүй бөгөөд Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлөөс албан хаагч нарт хүртээмжтэй үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан.</li> </ul>	100%
14	Албан хаагчдын ар гэрт гачигдал гарсан тохиолдолд цалинтай чөлөө олгож, мөнгөн тусламж үзүүлэх /Шаардлагатай тохиолдолд унаагаар үйлчлэх/	<ul style="list-style-type: none"> <li>Дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалтад хамаарах гачигдал тохиолдоогүй.</li> </ul>	0%
<b>ДӨРӨВ. АЛБАН ХААГЧДЫН МЭРГЭЖЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ</b>			
15	Албан хаагч дотоодын их, дээд сургуулийн Магистрын зэрэг горилсон бүтээл хамгаалах сард 5 хоногийн, докторын зэрэгт 10 хоногийн цалинтай чөлөө олгох	<ul style="list-style-type: none"> <li>Захиргааны албаны ахлах мэргэжилтэн Б.Мичид-Эрдэнэ нь ШУТИС-ын Бизнесийн ахисан түвшний сургуульд "Логистикийн менежмент"-ийн магистрын хөтөлбөрт суралцаж байгаа бөгөөд 2019.12.20-нд Магистрын зэрэг горилсон бүтээлийн урьдчилсан хамгаалалт болох тул 1 өдрийн цалинтай чөлөө олгохоор шийдвэрлэсэн.</li> </ul>	100%
16	Мэргэшсэн инженерийн багц сургалтад хамрагдах инженерүүдэд цалинтай чөлөө олгож, дэмжлэг үзүүлэн сургалтад хамруулах	<ul style="list-style-type: none"> <li>Үйлдвэрлэл, технологийн албаны инженер Б.Мөнгөнхуяг нь Дулаан хангамжийн мэргэшсэн инженерийн багц сургалтад хамрагдаж байна. Тус оны жилийн эцсийн байдлаар ажлын өдрүүдэд сургалтад хамрагдаагүй тул цалинтай чөлөө олгоогүй байна.</li> </ul>	0%

17	Мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх 3 сар хүртэл хугацааны сургалтад хамрагдаж буй албан хаагчдад чөлөө олгож ажлын байрыг хэвээр хадгалах	<ul style="list-style-type: none"> <li>Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн Э.Батболд нь мэргэшүүлэх 4 сарын сургалтад хамрагдахаар чөлөө хүссэн тул ажлын байрыг хэвээр хадгалж, түр орон тоогоор нээлттэй ажлын байр зарлан ажиллуулсан.</li> </ul>	100%
18	Гадаад улс руу хэлний бэлтгэл, мэргэжлийн сургалтад 6 сарын хүртэл хугацаанд суралцах албан хаагчдад чөлөө олгож, ажлын байрыг хэвээр хадгалах /1 албан хаагч 2 жилд 1 удаа/	<ul style="list-style-type: none"> <li>Одоогийн байдлаар гадаад улс руу суралцахаар явсан албан хаагч байхгүй байна.</li> </ul>	0%
19	Гадаад улсад магистр болон докторын зэрэг хамгаалах албан хаагчдад суралцах мэргэжлийн чиглэлээс хамааран 1,5-3 жилийн хугацаанд чөлөө олгож, ажлын байрыг хэвээр хадгалах	<ul style="list-style-type: none"> <li>Тайлант онд гадаад улс руу магистр болон докторын зэрэг хамгаалахаар явах хүсэлт гаргасан албан хаагч байхгүй байна.</li> </ul>	0%
20	Төрийн, төрийн бус болон олон улсын Манлайллын сургалтад суралцах шалгаруулалтад тэнцсэн албан хаагчдад чөлөө олгох	<ul style="list-style-type: none"> <li>Одоогийн байдлаар шалгаруулалтад оролцсон албан хаагч байхгүй байна.</li> </ul>	0%
<b>ТАВ. ХАМТ ОЛОН Ч СЭТГЭЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ</b>			
21	Хамт олны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор дотооддоо уралдаан, тэмцээн зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>Багануур дүүргийн Засаг даргын нэрэмжит спортын их наадмын 7 төрөлд паркийн албан хаагч нар идэвхтэй оролцсон бөгөөд Сагсан бөмбөгийн хамтарсан эмэгтэй баг дэд байр эзэлж амжилт үзүүлсэн.</li> <li>Нийслэл хот байгуулагдсаны 380 жил, Үйлдвэрлэл, технологийн паркууд байгуулагдсаны 5 жилийн ойг тохиолдуулан "Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк"-аас санаачлан зохион байгуулсан Спорт өдөрлөгт амжилттай оролцож Сагсан бөмбөг болон гар бөмбөгийн төрөлд тэргүүн байр, ширээний теннисний эмэгтэй төрөлд дэд байранд тус тус шалгарав.</li> </ul>	100%
22	Ажлын дадлага туршлага олгох зорилгоор салбарын томоохон байгууллага, үйлдвэрүүдтэй танилцах аяллыг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>Бүгд Найрамдах Буриад Улсын Аж үйлдвэрийн парктэй танилцах аялал зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг хангасан боловч үйлдвэрийн саналаар түр хойшлуулсан.</li> </ul>	100%

	<ul style="list-style-type: none"> <li>2019.06.21-ний өдөр БҮТП-д Биотехнологийг хөгжүүлэх нь уриан дор “Ховор эмийн ургамал, жимс жимсгэнэ тариалах нь” сэдэвт VI сургалт зөвлөгөөнийг дүүргийн үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулан амжилттай зохион байгуулж, Хөх нуурын био станц, Хэрлэн баян улааны ховор эмийн ургамлын плантацитай танилцаж туршлага судлав.</li> </ul>	
Хэрэгжилт тооцох боломжгүй ажлын тоо		7
<b>ДУНДАЖ ХУВЬ</b>		<b>100%</b>

ХЯНАСАН:  
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МИЧИД-ЭРДЭНЭ

5	Алсан хаагчид нэрт амьтны тус тусын орныг бүрдүүлж өгөх	<ul style="list-style-type: none"> <li>Байгууллагын өдрийн ажил нь технологийн зориулалттай өндөр тээвэр цахилгаан байрны тус албан хаагчдыг стандартын дагуу байрныг хангах үүднээс засвар хийж, өрөөний цэвэрлэг, хэрэгсэлтийн хэргийг тогтоосон.</li> <li>Туралтнуулагч байгууллагын Болов Мэдээлэл холбооны сүлжээ ТБХХ-д нэгдсэн танил ажил үйлдлийн өрөөнийг</li> </ul>	100%
---	---	---	------